



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ

Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ МЭДЭЭ

2020 оны 2-р сар




МХБ-ийн индексүүд

Топ-20 индекс, 19,092 **+1%** (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



МХБ-А индекс, 9,476 **+1.3%**, МХБ-В индекс 7,845 **+0.3%** (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



Олон улсын индексүүд

Индекс	2019.01.31	2020.02.29	Өөрчлөлт, %
DJIA (US)	28,256	25,409	-10%
S&P 500 (US)	3,225	2,954	-8.4%
Nikkei 225 (JP)	23,205	21,142	-8.9%
Hang Seng (HK)	26,312	26,129	-0.6%
DAX 30 (DE)	12,981	11,890	-8.4%
SMI (CH)	10,627	9,831	-7.4%

Валютын ханш

Валют	2019.01.31	2020.02.29	Өөрчлөлт, %
USD	2,751.57	2,762.71	0.4%
EUR	3,034.57	3,039.26	0.2%
JPY	25.25	25.37	0.5%
RUB	43.61	41.16	-5.6%
CNY	396.67	394.75	-0.4%
KRW	2.31	2.28	-1.3%

Арилжааны мэдээ

Хураангуй (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)

Үзүүлэлт	Дүн	Өөрчлөлт, %
Арилжааны хэмжээ, тэрбум ₮	4.2	-10%
Зах зээлийн үнэлгээ, тэрбум ₮	2,747.1	3.0%
Бүртгэлтэй компани	198	198
Арилжаалагдсан хувьцаа	72	-4
Арилжаалагдсан өдөр	17	-5

Хамгийн их өсөлттэй

Хувьцаа	2019.01.31	2020.02.29	Өөрчлөлт, %
CHE	214.08	900.00	+320%
NEH	12,010.00	15,790.00	+31.4%
JTB	70.00	90.99	+29.9%
UID	1003.00	1300.00	+29.6%
BUK	300.00	370.00	+23.3%

Хамгийн их бууралттай

Хувьцаа	2019.01.31	2020.02.29	Өөрчлөлт, %
CHR	330.00	240.00	-27%
BBD	66.00	49.00	-25%
HBO	70.00	55.00	-21%
ADL	1,350.00	1,101.00	-18%
SIL	50.00	41.00	-18%

Зах зээлийн мэдээлэл

Хувьцаат компаниудын ногдол ашгийн шийдвэр, тайлан

Хувьцаат компаниуд жил бүрийн 2-р сарын 20-ны дотор ногдол ашиг тараах эсэх тухай шийдвэрийг МХБ-д мэдэгдэж, хувьцаа эзэмшигчиддээ хүргэх үүргийг хүлээдэг. Тэгвэл МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниудаас 2020 оны 2-р сарын 20-ны байдлаар 95 хувьцаат компанийн ТУЗ шийдвэр ирүүлснээс 29 хувьцаат компани ногдол ашиг тараахаар, 2 компани ХЭХ-аараа эцэслэн шийдвэрлэхээр, бусад хувьцаат компаниуд нь ногдол ашиг тараахгүйгээр шийдвэрлэжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг http://mse.mn/mn/dividend_info/123 линкээр орж үзнэ үү.

Түүнчлэн, хувьцаат компаниуд ногдол ашиг тараахдаа зөвхөн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан тарааж байхыг Санхүүгийн зохицуулах хорооноос “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” 2020/01/29-ний өдрийн 28-р тогтоолоор үүрэг болголоо. Ингэснээр жижиг хувьцаа эзэмшигчид ногдол ашгаа авахад чирэгдэлгүй болж буй юм.

Мөн, жил бүрийн 2-р сарын 10-ны дотор хувьцаат компаниуд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа МХБ-д ирүүлэх үүрэгтэй байдаг. http://mse.mn/mn/company_finance_report/120 линкээр орж, компаниудын санхүүгийн тайланг сонирхоорой.

Буян ХК-ийн ногдол хувийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулав

Буян ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдан авах зорилгоор ногдол хувь болох нэгж хувьцаанд 400.00 төгрөг тараасныг 2020 оны 2-р сарын 11-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн ҮЦТХТ дэх дансанд байршуулжээ.

Код	Компанийн нэр	Бүртгэх өдөр	Нэгж хувьцаанд олгосон ногдол хувь/төг/	ХЭ-ийн тоо	Хувьцааны тоо	Дансанд байршуулсан ногдол хувь/төг/
121	"БУЯН"ХК (BYN)	2020-01-29	400.00	63	26,866	10,746,400.00

Тандэм инвест ББСБ ХК-ийн арилжааг сэргээв

МХБ-ийн III ангилалд бүртгэлтэй Баян алдар ББСБ ХК-д Монгорүматрикс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулж, оноосон нэрийг Тандэм инвест ББСБ ХК болгон өөрчилж, хувьцааг 50 хуваан, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан арилжааг түр хугацаанд зогсоосон байсныг 2020 оны 2-р сарын 14-ний өдөр сэргээв.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлан

МХБ-д 2019 онд шинээр үнэт цаасаа бүртгүүлж, олон нийтээс 18.46 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн Инвескор ББСБ ХК нь 2019 оны 12-р сарын 31-ний байдлаар татан төвлөрүүлсэн хөрөнгөө дорх байдлаар зарцуулжээ.

- Хэрэглээний зээл-11.1 тэрбум ₮
- ААН зээл – 4.6 тэрбум ₮
- Иргэдийн бизнесийн зээл – 1.8 тэрбум ₮
- Кредит карт – 0.9 тэрбум ₮

Мөн, МБХ-д 2018 онд үнэт цаасаа шинээр бүртгүүлж, олон нийтээс 6.4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн Монгол базальт ХК нь 2020 оны 2-р сарын 7-ны өдрийн байдлаар татан төвлөрүүлсэн хөрөнгөө дараах байдлаар залцуулжээ. Үүнд:

- Чулуун хөвөнгийн үйлдвэрийн өргөтгөл-2.5 тэрбум ₮
- Цахилгааны дэд станц – 1.1 тэрбум ₮
- Үйлдвэрийн барилга – 680.0 сая ₮

Хамгийн их арилжигдсан

Хувьцаа	Тоо ширхэг	Үнийн дүн. сая төг	Эзлэх %
HBO	16,630,066	770.1	39.6%
APU	738,690	463.1	23.8%
MNDL	3,099,034	160.9	8.2%
GOV	308,544	78.5	4.0%
MBW	216,172	53.1	2.7%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их өссөн, тэрбум төгрөгөөр

Компани	2019.01.31	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
CHE	13.7	43.9	+320.0%
NEH	13.2	4.1	+31.0%
JTB	7.0	2.0	+29.9%
UID	36.9	10.9	+29.6%
VIK	19.9	4.9	+25.0%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их буурсан, сая төгрөгөөр

Компани	2019.01.31	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
CHR	235.4	64.2	-27.2%
BBD	107.4	27.6	-25.7%
HBO	3,648.3	781.7	-21.4%
ADL	4,254.2	784.6	-18.4%
SIL	2,316.7	417.0	-18.0%

- Үйлдвэрт ашиглах машин механизм – 330.0 сая ₮
- Базальт карьерийн аж ахуйн тоног төхөөрөмж – 40.9 сая ₮
- Базальт карьерийн аж ахуйн машин механизм – 210.0 сая ₮
- Түүхий эдийн 4-н сарын нөөц – 599.0 сая ₮
- Урт хугацаат зээлийн эргэн төлөлт – 496.5 сая ₮

ҮЦТХТ-д нээгдсэн дансны мэдээлэл

ҮЦТХТ-д энэ оны 2-р сард нийт 36,019 данс нээгдснээс 31,793 данс шинээр, 4,226 данс холболтоор нээгдсэн ба шинээр нээгдсэн дансдын бүтцийг харвал 31,782 дотоодын иргэн, 3 гадаадын иргэн, 8 дотоодын аж ахуйн нэгжийн данс тус тус нээгдсэн байна.

ЭТТ-н 1072 хувьцаа – ногдол ашиг

Эрдэнэс тавантолгой ХК нь 2020 оны 2-р сарын 17-ны өдөр нэгж хувьцаанд 90₮ (10% татвар суутгагдаад 81₮) тараах шийдвэр гаргасан тухай олон нийтэд мэдээлсэн. Гэхдээ ногдол ашгийг 5-р сараас эхэлж, ондоо багтаан тараана гэж мэдэгдсэн. Тиймээс, харилцагчид манай цахим системд <https://dbx.standardinvestment.mn/> линкээр нэвтрэн бүртгүүлж, эсхүл 70114433 утсаар ярьж, ногдол ашиг авах дансаа баталгаажуулах хэрэгтэй юм. ЭТТ-н хувьцааны тоо ширхгийн талаар мэдээлэл авах бол <https://www.schcd.mn/?p=10334> линкээр орж харна уу.

ОНЦГОЙ БАЙДАЛ:



“ЦАХИМ ДАНС” СИСТЕМ

<https://dbx.standardinvestment.mn/>

Standard Investment

Available on the **App Store**

ANDROID APP ON **Google play**

Шинэ төрлийн корона вируус (COVID-2019)-ын тархалтаас сэргийлэх зорилгоор манайх 2020.04.01-ний өдрийг хүртэл оффис дээрээ харилцагч хүлээн авахгүй байгааг мэдэгдье. Бид онлайнаар, утсаар үйлчилгээгээ хэвийн үзүүлж буй ба Та бүхэн энэ хугацаанд манай цахим систем <https://dbx.standardinvestment.mn/> болон мобайл апп-аар (Standard Investment) хувьцааны данс нээлгэх, арилжаа хийх боломжтой юм. Асууж тодруулах зүйл гарвал 70114433, 99072783, 99027432 дугаарын утас эсвэл Standard Investment LLC фэйсбүүк пэйж хаягаар хандана уу. Баярлалаа!



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



МӨНГӨ, ЗЭЭЛ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2020 оны 1-р сарын эцэст 20.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.9 (4.6%) их наяд төгрөгөөр өсөхөд төгрөгийн хадгаламж 667.8 тэрбум төгрөгөөр, валютын хадгаламж 611.5 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2020 оны 1-р сарын эцэст 837.8 тэрбум болж, өмнөх оны мөн үеэс 201.4 (19.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна.


Хүснэгт. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, жилийн эцэст, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2019.01	2020.01*
Мөнгө M2	19,642.3	20,540.1
Бага мөнгө M1	3,678.2	3,655.5
Төгрөгийн харилцах	2,983.6	3,088.8
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	694.6	566.7
Бараг мөнгө	15,964.1	16,884.6
Төгрөгийн хадгаламж	10,180.3	10,848.1
Валютын хадгаламж	2,945.5	3,557.0
Валютын харилцах	2,838.3	2,479.5
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	1,039.2	837.8

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 1-р сарын эцэст 18.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 871.7 (5.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 1-р сарын эцэст 925.2 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 101.2 (12.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 90.6 (10.9%) тэрбум төгрөгөөр өсчээ. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 1-р сарын эцэст 1.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 10.3 (0.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 47.5 (2.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 54. Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төгрөг



УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн нийт хэмжээ 2020 оны 1-р сарын урьдчилсан гүйцэтгэлээр 767.7 тэрбум төгрөг, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 708.4 тэрбум төгрөг болж нийт орлогын 92.3 хувийг эзэлж байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 643.1 тэрбум төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 67.2 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.




Эх сурвалж: Монгол улсын үндэсний статистикийн хороо



ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.6 тэрбум ам. долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 497.8 сая ам. доллараар буурчээ. Урсгал данс 1.7 тэрбум ам. долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 1.6 тэрбум ам. доллар, анхдагч орлогын данс 1.6 тэрбум ам. долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 63. Бараа болон үйлчилгээний худалдаа, сараар, сая америк доллароор




Төлбөрийн тэнцэл 2018 онд 141.7 сая америк долларын алдагдалтай байсан бол 2019 онд өмнөх оноос 594.6 сая америк доллароор өсөж, 452.9 сая америк долларын ашигтай гарчээ.



ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2020 оны 1-р сард нийт 116 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 932.3 сая ам. доллар, үүнээс экспорт 459.0 сая ам. доллар, импорт 473.3 сая ам. долларт хүрлээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 178.9 (16.1%) сая америк доллар, үүнээс экспорт 148.2 (24.4%) сая ам. доллароор, импорт 30.7 (6.1%) сая америк доллараар түс түс буурчээ.

Зураг 64. Экспорт, импорт, тэнцэл, сараар, сая америк доллар




Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2019 оны 1-р сард 103.3 сая америк долларын ашигтай гарч байсан бол 2020 оны 1-р сард өмнөх оны мөн үеэс 117.5 сая америк доллароор буурч, 14.3 сая америк долларын алдагдалтай байна.



ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 1-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.9 хувь, өмнөх оны эцсээс 5.6%-р өссөн байна.

Зураг 68. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 1-р сард өмнөх оны мөн үеэс 5.6%-р өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.8% (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 15.8%, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 4.0%), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.7%, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 6.7%, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 5.2% (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 4.5%), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.3%-р өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Холбоо барих хаяг

Стандарт инвестмент ҮЦК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
6-р хороо, Бага тойруу 24,
Монреимпекс ХХК-ийн байр,
2-р давхар, 201 тоот

Утас: 70114433
info@standardinvestment.mn
www.standardinvestment.mn

Шуудангийн хаяг:

Төв шуудан, Шуудангийн хайрцаг 1487
УБ - 15160

Тодруулга болон мэдэгдэл

Энэхүү тойм мэдээ нь ямар нэгэн үнэт цаасыг худалдан авах, худалдах санал биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно /Стандарт инвестмент ҮЦК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Хөрөнгө оруулагч эрсдлийг өөрөө хариуцна.

Энэхүү тойм мэдээний бүх мэдээллийг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт инвестмент ҮЦК нь эдгээр мэдээллийн үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн, энэхүү тайланг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт инвестмент ҮЦК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.